



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/443

Булган сум

Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Алтаргана 2024” олон улсын XV их наадмын дэд ажлын хэсгийн хувцас поло подвалк, малгай, ажлын хэсэг, шүүгч, хэвлэл мэдээллийн салбар, хүндэт зочдод олгох мандат бэлтгэх ажлын гүйцэтгэгчээр “ЛАБЕЛ БРЕНД” ХХК-ийг сонгож, 19,800,000 (арван есөн сая найман зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулан, хяналт тавьж, хүлээн авахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д үүрэг болгосугай.

2. “Алтаргана 2024” наадмын ажлын хэсгийн хувцас поло подвалк, малгай, ажлын хэсэг, шүүгч, хэвлэл мэдээллийн салбар, хүндэт зочдод олгох мандат бэлтгэх ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэн хүлээлгэн өгөхийг “ЛАБЕЛ БРЕНД” ХХК-ийн захирал (Б.Батдэлгэр) -д даалгасугай.

3. Санхүүжилтийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн “Алтаргана 2024” арга хэмжээний төлөвлөгдсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6324010578

Аймгийн Засаг даргын 20.... оны
..... дүгээр сарын.....-ны өдрийн..... дугаар
захирамжийн хавсралт

“Алтаргана 2024” олон улсын XV их наадмын ажлын хэсгийн хувцас, мандатын
зардлын тооцоо

Д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	1	2	3	4
1	Мандат	2300ш	4500	10,350,000
2	Поло подвалк	150ш	45,000	6,750,000
3	Малгай	150ш	18,000	2,700,000
Нийт үнэ				19,800,000